



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 91/133

Улаанбаатар хот

Байгууллагын дотоод үнэлгээ зохион
байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын “Нийслэлийн нутгийн Захиргааны байгууллагуудын засаглалын төлөв байдлын үнэлгээ” байгууллага дотооддоо үнэлгээ зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу үнэлгээний цахим маягтыг ашиглан байгууллагын дотоод үнэлгээг үнэн зөв, бодит мэдээлэлд тулгуурлан, чанартай, үр дүнтэй зохион байгуулж, тайлагнаж ажиллах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Хүнс худалдаа Үйлчилгээний хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Архивын хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга

1525010413

Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөц,
ёс зүйн асуудал хариуцсан Ахлах мэргэжилтэн
Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн Иргэдийн
өргөдөл гомдол, санал хүсэлт, тогтоол
шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга: Засаг даргын Тамгын газрын Төрийн
Захиргааны удирдлагын хэлтсийн захиргааны
зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн

2. Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор тайлагнаж ажиллахыг Ажлын хэсэг (О.Батмөнх)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ